БАТЛАВ: ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Л.ТӨМӨРЧӨДӨР

9059008 ☎ СБТ27017

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМАНД ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025.11.20 **Зуунмод**

№	Нэр, төрөл	Үзүүлэлт
1	Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, зорилго	Төрийн албан хаагч болон зорилтот бүлгийн иргэдийг инженерийн бүрэн хангамж бүхий хямд өртөгтэй, чанартай түрээсийн орон сууцаар хангах,хүн амын худалдан авах чадварт тохирсон орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Зуунмод суманд түрээсийн орон сууцны зориулалтаар ашиглагдах орон сууц худалдан авах түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх.
2	Захиалагч байгууллага	ТӨВ АЙМГИЙН БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГазар
3	Зориулалт	Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх
4	Байршил	Төв аймаг, Зуунмод
5	Хүчин чадал	1 байр нь 50 м2 хүртэл, орон сууцны урьдчилгаа 30 хувийг Төр олгох.
6	Хамрах хүрээ	Зуунмод хотод шинээр баригдаж байгаа болон ашиглалтад бүрэн орсон орон сууцны барилга байгууламжийг гүйцэтгэж буй аж ахуй нэгж
7	Барилга, байгууламжийн чанар стандартын шаардлага	-Хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байх -Чанарын баталгаажсан гарал үүслийн гэрчилгээтэй/лабораторийн батламжтай бүтээгдэхүүн ашигласан байх/ -Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, зураг төсвийн шаардлагыг бүрэн хангасан байх.
8	Барилга, байгууламжийн угсралтын ажлын гүйцэтгэлийн байдал	Ашиглалтын нөхцөл шаардлагыг бүрэн хангасан, гэрчилгээ, паспорт, инженерийн бүрэн хангамж бүхий шинээр 2025-2026 оны эхний хагас жилд ашиглалтад орох орон сууцны зориулалттай барилга.
9	Барилга угсралтын компанид тавигдах шаардлага	-Орон сууцны барилга, байгууламжийн түвэгшлийн зэрэгт тохирсон барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд. -Барилгын үйл ажиллагааг эрхэлсэн туршлага 3 ба түүнээс доошгүй жил байна. -Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх инженер техникийн ажилтан бүхий хүний нөөцтэй байх ба ерөнхий инженерийн ажлын туршлага 3 ба түүнээс доошгүй байх. -Барилгын үйл ажиллагаа эрхлэх техник, тоног төхөөрөмж бүхий үйлдвэрлэлийн бааз суурьтай байх.
10	Түрээсийн орон сууц нийлүүлэх хугацаа	Гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ.
11	Галын аюулгүй байдлын нөхцөл	"Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал" БНбД 21,01,02 "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНбД 21,01,02 болон галын аюулгүй байдлын бусад стандарт, норм, дүрмийн дагуу төлөвлөгдсөн барилга байгууламж байх.
12	Хамтын ажиллагаа	Төр, Банк, Гүйцэтгэгч нар хамтран ажиллах. /30:70:100/
13	Түрээсийн орон сууцны худалдан авах санхүүжилт	1 байрын үнийн дүнгийн урьдчилгаа 30 хувийн олгох, нийт 550,000,000/Таван зуун тавин сая/ төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн барилга, байгууламжийн гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлнэ. Багц1; 320.000.000 /Гурван зуун хорин сая/ Багц2; 230,000,000 /Хоёр зуун гучин сая/ Гүйцэтгэгч шалгарсан.
14	Захиалагчийн хяналт тавих.	БЗОСК ОНӨААТҮГ-тай үнийн дүнгийн 2 хувиар гэрээ байгуулах.
15	Онцгой нөхцөл	-Газар хөдлөлтийн 8 баллд тэсвэртэй, газар хөдлөлтийн үеийн аюулгүй байдал нөхцөл шаардлагыг хангасан байх.

		-Байгаль цаг уурын үзүүлэлтүүдэд тулгуурлан үер, бороо,усны хамгаалалт төлөвлөгдсөн. -Аваарын гарцтай -Ажлын эзлэхүүнд тусгагдсан бусад шаардлага хангасан.
16	Тавигдах шаардлага	-Эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан зураг төслийг магадлалаар хянан баталгаажуулсан. -Эрчим хүч, усан хангамж, ариутгах татуурга, харилцаа холбооны систем нь хэмнэлт үр ашигтай байхаар төлөвлөгдсөн. Нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто зогсоол түүний орц гарцыг хөдөлгөөнд саадгүй байхаар төлөвлөсөн. -Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлага хангасан. -Орчны архитектур төлөвлөлттэй уялдуулан гадна засал, тагтны хашлага, хаалтыг төлөвлөсөн байна. -Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байна. -Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 15%-иас дээш гүйцэтгэлтэй байх. -Төлөвлөлтөөр баригдаж байгаа орон сууц бол давуу тал болно.

Боловсруулсан: БЗОСК ОНӨААТҮГ-н захирал Ц.ДАШДЭМБЭРЭЛ

ТӨВ АЙМГИЙН БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ 3871185 4117252759